



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/274

Арвайхээр сум

**Стратегийн команд штабын сургуулийн
бэлтгэл хангах ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн “Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай” 06 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2023 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуульд оролцох бэлтгэл ажлыг хангах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ажлын хэсгийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

3. Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл хангах ажлын хүрээнд шаардагдах зардлын тооцоог гаргаж, зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т даалгасугай.

4. Стратегийн команд штабын сургуульд чиг үүргийн дагуу бэлтгэл, бэлэн байдлаа хангаж оролцохыг гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн дарга, бүх шатны Засаг дарга нарт тус тус даалгасугай.

5. Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”-ын дагуу иргэдийг аюулгүй талбайн цугларах цэгт гаргах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Д.Одонбаяр), Арвайхээр сумын Засаг дарга (Б.Ганбат), аж ахуйн, нэгж байгууллагын удирдлага, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, бэлтгэл ажлын үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0519

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дүгээр
сарын 08-ны өдрийн 105 дугаар
захирамжийн хавсралт

**СТРАТЕГИЙН КОМАНД ШТАБЫН СУРГУУЛИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ
ХАНГАХ ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын орлогч

Ажлын хэсгийн орлогч: Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч,

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Арвайхээр сумын Засаг дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого,
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
Цагдаагийн газрын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
Эрүүл мэндийн газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн
ажилтан

Нарийн бичгийн дарга:

Онцгой байдлын газрын Орлогч, Урьдчилан сэргийлэх
тасгийн дарга

-оОо-